ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ЭМ БИОБЭЛДМЭЛИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.ПҮРЭВСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”** | | | | | | | |
| 1. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -Албан тушаалын тодорхойлолт батлагдсан.<br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх биелэлтийн тайланд эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр хүргүүлэх мэдээ, мэдээллийг сар, улирлаар тайлагнаж ажилласан байна.<br>-Засгийн газрын 2023 оны хөтөлбөр, стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан эм биобэлдмэлийн хяналтын чиглэлийн тогтоол, шийдвэрийн биелэлт, хуулийн хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн. | Импортын эм, эмнэлгийн хэрэгслийн хууль эрх зүй, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ахиц гаргах, үр дүнтэй болгох асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагатай уялдаа холбоотой ажиллаж, санал хүргүүлэх | -“Алсын хараа 2050” урт болон дунд хугацааны, Засгийн газрын 2021-2024 оны хөтөлбөр, Гаалийн байгууллагын стратегийн зорилтод хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой зорилтын биелэлтийг эм бибэлдмэлийн хяналтын чиглэлээр хэрэгжүүлж ажилласан.<br>-Засгийн газрын хөтөлбөр болон бусад тогтоол, шийдвэр, биелэлт, хуулийн хэрэгжилтийн тайланд эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр биелэлт гаргаж, холбогдох албан хаагчид хүргүүлж ажилласан.<br>-Эм биобэдлмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор хорио цээрийн хэлтсийн ГУАБ-д санал хүргүүлсэн.<br>-Магадлан шинжилгээ хийх А/315 тоот журамд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор холбогдох албан тушаалтанд 4 санал хүргүүлсэн.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйлд өөрчлөлт орсон. Иймд тус хуулийн 227 дугаар зүйлийн 227.10-т заасны дагуу Зорчигчийн хувийн хэрэглээний эмийн | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүртгэлийн системийг CAIS системд нэвтрэх хүртэл бүртгэх бүртгэлийн хүснэгтийг боловсруулж, харьяа гаалийн газар хороод руу 02-1/3979 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуулинд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн боловч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэгт өөрчлөлт ороогүй орхигдсон тул тус хуулийн дээрх заалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хийдлийг арилгах саналыг хуулийн хэлтэст хүргүүлсэн.<br><br>“Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журмын төсөлд 3 саналыг хүргүүлж, ЭЭХХЗГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/190 тоот тушаалаар батлагдсан “Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах журам боловсруулах, жагсаалтын төслийг боловсруулах” ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, 2 удаагийн хуралдаанд оролцож, санал хүргүүлэн, ЭЭХХЗГ-тай уялдаа, холбоотой ажиллаж байна. | | |
| 2. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хууль эрх зүйн чадавхийг бэхжүүлэх зорилгоор 2023 онд ГЕГ-ын даргын 4 тушаал батлуулахад санал хүргүүлсэн. | Хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн байна.<br>Хорио цээрийн чиглэлээр холбогдох тушаал, зааврыг батлуулна. | -Эрүүл мэндийн яаманд 2024 оны 02 дугаар сарын 23-ны 02/679 тоот албан тоотоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2 санал, дагалдан гарах хуулийн төсөлд 4 саналыг хүргүүлсэн.<br>Нийгмийн бодлогын байнгын хорооны дэргэдэх дэд ажлын хэсэгт ажиллаж, эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн дэд ажлын хэсгийн хуралд 4 удаа, байнгын хорооны хуралд 2 удаа, УИХ-ын нэгдсэн чуулганы хуралд 1 удаа оролцсон. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эм, эмнэлгийн хэрэгсийн тухай хуулийг 2024 оны 06 сарын 05-ны өдөр УИХ-аар эцэслэн батлагдсан.<br>-Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэст "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн төсөлд №29 тоот дотоод зурвасаар 2 санал хүргүүлсэн.<br>-Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор тус хуулийн 227-р зүйлд /зорчигчийн хувийн хэрэглээний эмийн тухай заалт/ 2 санал хүргүүлэн ажилласан.<br>- ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 сарын 11-ний өдрийн А/44 тушаалаар батлагдсан Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан эрүүл мэндийн тухай хууль болон зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, үзэл баримтлал боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, 3 удаагийн хуралдаанд оролцож, "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуулийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлсэн.<br>Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох тухай журмын төсөлд 2024 оны 09 сарын 05-ны 02-1.2/3552 тоот албан бичгээр ЭЭХХЗГ-т 3 санал хүргүүлсэн.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх болсонтой холбоотойгоор харъяа гаалийн газар хороод руу 02-1/3979 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн. | | |
| 3. | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн хорио цээрийн хяналтад хамрагдаж байсан импортын 2301 бараанаас улбар шар төлвийн 121 барааг хорио цээрийн хяналтын чиглэлээс чөлөөлсөн. | Хорио цээрийн хяналтад хамрагдах барааны эрсдэлийн шалгуурыг боловсруулж эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг | -Эм биобэлдмэлийн хяналтад заавал хамрагдах барааны жагсаалтыг БТКУС-ын 8 орны түвшинд гаргаж, гадаад худалдааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлсэн.<br>-Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр өгөгдөл солилцооны модулиар солилцох | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | | Кайс систем дэх "Хорио цээрийн бүртгэл" талбарын хорио цээрийн хяналтад хамрагдах экспортын 2240 нэрийн бараанд БТКУС-ын ангиллаар дүн шинжилгээ хийж, 960 нэрийн барааг эрсдэлийн "заавал" шалгуураар хянах зохицуулалтыг бий болгосноор хорио цээрийн чиглэлээр экспортын хяналтад хамрагдах бараа 57 хувиар буурсан байна. | хэрэгжүүлж улаан төлөвт шалгагдах барааны тоог бууруулна.<br><br>-Хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгоно. | мэдээлэл боловсруулж, хариуцсан байцаагчид хүргүүлсэн<br>-Гаалийн эрсдэлийн нэгдсэн удирдлагын журмыг шинэчлэн батлуулахтай холбоотой эрсдэлийн шалгуурыг тодорхой болгох, журамд 2 санал өгч ажилласан.<br>-Эм биобэлдмэлийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгосон.<br>-Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт ашиглах заврын загвар, заавран нэр, төрлийн жагсаалтыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 06/06 тоот шийдвэр гарсаны мөрөөр Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/380 тоот тушаалаар батлуулсан.<br>-Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр хийгдэж байгаа хяналт шалгалтын талаар Монгол телевиз болон Eagle телевизийн "Эмийн чанар ба үнэ" сэдэвт нэвтрүүлэгт мэдээлэл өгч ажилласан. | | |
| 4. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааг шалгах 32 хяналтын хуудсыг цахимжуулах бэлтгэл ажил хийгдсэн. | Хяналтын хуудсыг цахимжуулж, аргачлал, зааврыг гарган, КАЙС системд улсын байцаагчдад санамж хэлбэрээр харагддаг болгох | Хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах А/115 ажлын хэсгийн хүрээнд Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааг шалгах 32 хяналтын хуудсыг цахимжуулахтай холбоотойгоор 9.3.4 кодтой "Эм, биобэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл импортлох үеийн хяналтын хуудас"-ыг хяналт шалгалт хийх 7 төрлийн зааврын төсөл боловсруулан, тестийн системд оруулсан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| | | | Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь" төслийн хүрээнд ГЕГ-ын | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжин | "Хилийн хяналт удирдлагын систем"-ийн хөгжүүлэлтийн хүрээнд www.gaali.mn цахим системээр дамжуулан гаалийн харилцаанд оролцогчдын өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах нэгдсэн сувгийг бий болгох, хорио цээрийн эрсдэл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | даргын 2023 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг гаалийн хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах 16 модулыг боловсруулж, энэ хүрээнд одоогийн үйл ажиллагааны /AS-IS/ болон ирээдүйн үйл ажиллагааны системийн зорилтот /To-Be/ загварчлалыг бэлэн болгосон. | системчлэгдэж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх | тооцох аргачлалыг програмчлах, гаалийн автоматжуулсан цахим системийн зарим модулийг гар утасны программд шилжүүлэн ашиглах зэрэг төлөвлөгдсөн ажлуудыг төсөл хэрэгжүүлэх хугацаанд гүйцэтгэлийг хангуулж, тайлагнасан.<br>Зорчигчийн эмийн бүртгэлийн системийг боловсруулж, программын түвшинд санал өгч, цахим системийн тестийн орчинд нэвтрүүлэхэд бэлэн болгосон. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| **Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 1 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт,шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Эм биобэлдмэлийн хяналтад хамаарах барааг үнэн зөв мэдүүлэх шаардлагыг хангуулан, газар хороодын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдад үйл ажиллагаатай нь холбоотой зөвлөгөө, мэдээлэл, чиглэл өгч, эм биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдад сургалт зохион байгуулж, тухай бүр мэргэжиларга зүйгээр ханган ажилласан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх мэдээнд улсын хилээр нэвтрүүлж буй эм биобэлдмэлийн хяналтын талаарх зөрчлийн мэдээг | Улсын хилээр нэвтрүүлж буй бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. | -Эм, биобэлдмэлийн хяналтын чиглэлээр улсын хилээр нэвтрүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэлд стандарт, чанарын хяналт хийх, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомж, стандарт, чанарын шаардлагыг хангуулахад чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэн, хууль бус бараа тээврийг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, эрсдэлд суурилсан хяналтыг хийж ажилласан.<br>-2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монгол улсын хилээр 3164.1 тн эм, 298.89 тн эмийн түүхий эд, 1040.91 тн биологийн идэвхт бүтээгдэхүүн/шинэ хуулиар эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн/, 1302.23тн эмнэлгийн хэрэгсэл, 452.5 тн оношлуур импортын хяналтад хамрагдсан.<br>-2024 оны жилийн эцсийн байдлаар эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр нийт **242 зөрчил** илэрснээс **55 зөрчлийг** Зөрчлийн тухай хуулийн **6.6.2 дахь заалт** /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих/, **188** зөрчлийг Гаалийн тухай | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүргүүлэн, тайланд дүн шинжилгээ хийж ажиллав. Хагас жилийн байдлаар 21 зөрчил илэрсэн бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 6.6.2 дахь заалтын дагуу арга хэмжээ авч ажилласан. | | хуулийн 11.21.11 дэх заалтаар тус тус шийдвэрлэсэн байна.<br>Дээрх зөрчлүүд нь Дорнод гаалийн газар, СЭГГ, ЧХОУНБГГ, Замын-Үүд гаалийн газарт илэрсэн байна. Зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 6.6.2 дахь заалтаар шийдвэрлэсэн бөгөөд зөрчилд холбогдсон 10 аж ахуйн нэгжид 10000 нэгж буюу 10 сая төгрөгийн торгууль, 188 иргэнд 188000 нэгж буюу 18 сая 800 мянган төгрөгийн торгууль ногдуулж 100 хувь барагдуулж ажилласан байна.<br>Нийт зөрчлийн ихэнх хувийг улсын хилээр нэвтрүүлж буй эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүй, Монгол Улсын эмийн болон биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлд бүртгүүлээгүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэх, иргэн зорчигчийн хувийн хэрэглээнээс их хэмжээтэй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн хилээр нэвтрүүлэхээр завдсан зөрчил эзэлж байна. Зөрчилд холбогдсон 10 аж ахуйн нэгж нь Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэсэн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлохдоо Монгол улсын бүртгэлийн дугаарыг бичээгүй, бүртгэлийн загвараас зөрсөн эм импортолсон зэрэг зөрчил илэрсэн байна.<br>-Монос фарм ХХК-ийн Словени улсын КРКА эмийн үйлдвэрээс импортолсон 1 нэрийн 384 хайрцаг “Нолицин” шахмал эм бүртгэлийн загвараас зөрсөн, Вэлл бий ХХК-ийн 7 нэрийн эмийн шошгонд улсын бүртгэлийн дугаар зөрсөн, Юниверсал ложистикс Монголиа ХХК-ийн 1 нэрийн БИБ нь бүртгэлийн загвараас зөрсөн, Файер ХХК нь Турк улсын гарал үүсэлтэй 16 нэр төрлийн эмийг тусгай зөвшөөрөлгүй, гаалийн байгууллагад мэдүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зөрчилд холбогдсон эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг хуулийн дагуу хураан авч, харъяалах орон тооны бус зөвлөлд шилжүүлэх, гарал үүслийн оронд буцаах арга хэмжээ авч ажилласан.<br>2023 оны жилийн эцсийн мэдээнээс харахад 99 зөрчил илэрсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 143 зөрчлөөр нэмэгдсэн байна. Энэ нь Зорчигчийн хувийн хэрэглээнээс илүү хэмжээгээр эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан зөрчил ихэнх хувийг эзэлж байна. | | |
| 2. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хилийн нэвтрэх цэгийн тусгаарлах өрөөний тоног төхөөрөмж, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдлын судалгааг боомтуудаас авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангаан ажилласан. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ. | -ДЭМБ-аас сэрэмжлүүлсэн эм биобэлдмэлийг харьяа гаалийн газар хороодын гаалийн улсын байцаагчид хурдан шуурхай мэдээлж, гаалийн хилээр нэвтрүүлэхгүй буцаах үйл ажиллагааг хуулийн дагуу арга хэмжээ авч, шийдвэрлэхэд мэргэжил арга зүйгээр тухай бүр хангаж ажилласан.<br>-Хилийн нэвтрэх цэгийн тусгаарлах өрөөний тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, яаралтай тусламжид шаардлагатай эмийн бэлэн байдлын судалгааг боомтуудаас авч нэгтгэх, яаралтай тусламжийн эм биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын бэлэн байдлын судалгаанд дүн шинжилгээ хийх, мэргэжил арга зүйгээр хангаан ажилласан.<br>-Гаалийн байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харъяа гаалийн газар, хороодын эм биобэлдмэлийн болон химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдын эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн, химийн хорт болон аюултай бодисыг хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтад гарч буй алдаа, дутагдлыг залруулах, цаашид анхаарах асуудлын | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар нэгдсэн ойлголт өгөх, хувь хүний харилцааны болон мэдээллийн технологийг ашиглах чадварыг сайжруулах, хилээр хууль бус эд зүйл нэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор сургалтыг 2024 оны 09 сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>Сургалтад харьяа гаалийн 13 газар, хорооны 34 улсын байцаагчид хамрагдсан.<br>Сургалтын үйл ажиллагааг ЗУГ-ын дарга Б.Хосбаяр нээж, Хорио Цээрийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч Т.Төмөрбаатар чиглүүлж, ЭЭХХЗГ-ын Лиценз, тусгай зөвшөөрлийн газрын дарга Л.Зэндмаа, Биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл хариуцсан мэргэжилтэй Ш.Ариунзаяа, БОУАӨЯ-ны мэргэжилтэн н.Ананд нар мэдээлэл өглөө.<br>Сургалтад ГЕГ-ын БАҮХ-ийн дарга Ч.Чимгэрэл, ХХ-ийн ГУБ Э. Ганболд, Төв лабораторийн ГУАБ Г.Мөнхцацрал, Сургалтын төвийн багш Д.Булгантамир нар мэдээлэл өгч, хяналт шалгалт хийхэд анхаарах асуудлын талаар харилцан ярилцсан.<br>-Мөн ЧХОУНБГГ, УХШИГГ-ын улсын байцаагчдад Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчлэл, гол гол өөрчлөлт болон хяналт шалгалтын үйл ажиллагаанд анхаарах асуудлын талаар хичээл бэлтгэн, сургалт зохион байгуулсан. | | |
| 3 | Бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор лабораторийн шинжилгээнд | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр лабораторийн шинжилгээний дүнг авч үзэхэд: СЭГГ –аас 2 эмийн дээж, ЧХОУНБДГГ-аас 2 эмийн | Лабораторийн шинжилгээний зөрөг дүн буюу шаардлага хангаагүй үзүүлэлтэд дүн шинжилгээ хийнэ. | -2024 оны жилийн эцсийн байдлаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм шинжлэх лаборатори руу УБГГ-аас 27 нэрийн эмийн дээж шижилгээнд хамруулсан бөгөөд зөрөг сорьц илрээгүй байна. Дээрх 27 нэрийн эм нь фармакопейн болон сертификат анализын шаардлага | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулсан үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх | | дээж, УБГГ-аас 28, нийт 32 эмийн дээж шижилгээнд хамруулснаас 100 хувь фармакопейн болон сертификат анализын шаардлага хангасан байна. | Лабораторийн шинжилгээт хяналтын талаар газар, хороодыг мэргэжил арга зүйгээр хангана. | хангасан байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн дээжийнд хамруулсан шинжилгээний тоотой харьцуулахад 5 дээжээр буюу 15.63 хувиар буурсан байна.<br>-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын эм шинжлэх лабораторийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй, урвалж бодисын хангалтгүй байдлаас нийт импортлогдож байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээнд бүрэн хамруулж чадахгүй байна. | | |
| 4 | Бараа, тээврийн хэрэгслийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтын мэдээ, мэдээллийг гаргаж холбогдох байгууллага, удирдлагыг мэдээллээр хангах, ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Холбогдох мэдээллийг төрийн захиргааны болон дээд байгууллагад шуурхай хүргэж, мэдээллийн нэгдмэл, тасралтгүй байдлыг хангаж ажилласан. | Хуульд заасны дагуу холбогдох мэдээллийг гаргаж, холбогдох төрийн байгууллагад хүргүүлэхэд хяналт тавина.<br>Ажлын хэсэгт ажиллаж төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах, шаардлагатай асуудлыг бодлого шийдвэрт тусгуулна. | -Эм биобэлдмэлийн хяналтын талаарх мэдээ, мэдээллийг нэгтгэн цаг үеийн асуудлаар зохион байгуулагдсан хэлэлцүүлэг, хурал цуглаанд шаардлагатай мэдээ мэдээллийг гаргаж, хэлтсийн даргад хүргүүлсэн.<br>-ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 сарын 11-ний өдрийн А/44 тушаалаар батлагдсан Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан эрүүл мэндийн зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, үзэл баримтлал боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, ажлын хэсгийн хуралд 2 удаа оролцсон. Ажлын хэсгийн хуралд 2 санал хүргүүлэн ажилласан.<br>-edoc.ecustoms.mn-ээр ирүүлсэн 19 албан бичгийг болон ГЕГ-ын бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн дотоод зурвасын хариуг хугацаанд нь 100 хувь шийдвэрлэж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| 5 | Гаалийн хорио цээрийн цахимжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааг шалгах 32 хяналтын хуудсыг цахимжуулах бэлтгэл ажил хийгдсэн. | Хяналтын хуудсыг цахимжуулж, аргачлал, зааврыг гарган, КАЙС системд улсын байцаагчдад | Хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах А/115 ажлын хэсгийн хүрээнд Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааг шалгах 32 хяналтын хуудсыг цахимжуулахтай холбоотойгоор 9.3.4 кодтой "Эм, биобэлдмэл, биологийн | 2024.01.01<br>2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | санамж хэлбэрээр харагддаг болгох | идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл импортлох үеийн хяналтын хуудас"-ыг цахимжуулахтай холбоотойгоор хяналт шалгалт хийх зааврын төсөл боловсруулан ажилласан. | | |
| | | | Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь" төслийн хүрээнд ГЕГ-ын даргын 2023 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг гаалийн хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах 16 модулыг боловсруулж, энэ хүрээнд одоогийн үйл ажиллагааны /AS-IS/ болон ирээдүйн үйл ажиллагааны системийн зорилтот /To-Be/ загварчлалыг бэлэн болгосон. | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжин системчлэгдэж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх | "Хилийн хяналт удирдлагын систем"-ийн хөгжүүлэлтийн хүрээнд www.gaali.mn цахим системээр дамжуулан гаалийн харилцаанд оролцогчдын өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах нэгдсэн сувгийг бий болгох, хорио цээрийн эрсдэл тооцох аргачлалыг програмчлах, гаалийн автоматжуулсан цахим системийн зарим модулийг гар утасны программд шилжүүлэн ашиглах зэрэг төлөвлөгдсөн ажлуудыг төсөл хэрэгжүүлэх хугацаанд гүйцэтгэлийг хангуулж, тайлагнасан. | | |
| 6 | Ажлын цаг ашиглалт | | Ажлын цаг ашиглалт 100% байна. | Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. Ажлын цаг ашиглалтыг 100 хувь хангасан байна. | -Тайлангийн хугацаанд ажил тасалсан, хоцорсон удаагүй. | 2024.01.01 2024.12.10 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хэлтэст ирсэн албан бичгийн бүртгэл хөтлөх, удирдлагын цохолтын дагуу байцаагчдад хүргэх, мэдээллээр хангах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Хэлтсийн даргын цохсон албан бичгүүд холбогдох албан хаагчид хүргэгдэн, шийдвэрлэгдсэн байна. | Ирсэн албан бичгүүд хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар Төрийн байгууллага болон иргэд, аж ахуй нэгжээс ирсэн 528 албан бичиг болон өргөдөл гомдлыг бүртгэлжүүлж, холбогдох албан тушаалтанд хүргэж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| 2 | Гаалийн улсын байцаагчдын сул орон тоо зарласантай холбоотойгоор шалгалтад тэнцсэн гаалийн улсын байцаагчдад хичээл заах | Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох, чиглүүлэх сургалтад хичээл орох | ГЕГ-ын дарга болон газар, хэлтсийн дарга нараас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан. | Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох, чиглүүлэх сургалтад хичээл орж, эм биобэлдмэлийн хяналтын талаар анхан шатны мэдлэг олгосон байна. | Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад Эм биобэлдмэлийн хяналтад хэрэгжүүлж ажилладаг хууль эрх зүй, анхаарах асуудал болон Эм эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн асуудал, ажлын талбар дээр ажиллахад анхаарах асуудлын талаар 45 минут болон 1 цаг 30 минутын хичээл бэлтгэж, 4 удаагийн хичээлээр 185 шинэ байцаагч нарт анхан шатны мэдлэг олгосон. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| 3 | Даргын өгсөн үүрэг даалгавар болон албан бичгээр ирсэн агуулгын дагуу сургалт, семинар хэлэлцүүлэгт оролцох, үүрэг даалгаварыг биелүүлэх | Сургалт, семинарт оролцсон тоо, үүрэг даалгаврын тоо | ГЕГ-ын дарга болон газар, хэлтсийн дарга нараас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл өгч, тухайн зохион байгуулагдаж байгаа хэлэлцүүлгээс тодорхой мэдээлэл авсан, даргын өгсөн үүрэг даалгаварыг биелүүлсэн байна. | Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/458 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчид цол, олгох, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд хэлтсийн саналыг хүргүүлсэн. Журмын 3.2.1, 3.3.1, 3.4.1 дэх хэсэгт “мэргэжлийн хяналтын байгууллагад улсын байцаагчаар” гэж зохицуулсныг “хэвээр үлдээх” санал хүргүүлсэн.<br>“Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцлийг хянан шалгах үүрэг бүхий Түр хороо”-ны 2024 оны 03 сарын 01-ний өдрийн №УИХ-16/1579 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу мэдээлэл бэлтгэж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.<br>Хяналт бүрдүүлэлтийн газарт “Эм биобэлдмэлийн хяналтын өнөөгийн | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байдал, цаашид авах арга хэмжээний санал” болон сүүлийн 3 жилийн зөрчлийн мэдээ, хурааж устгасан эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн мэдээг хүргүүлсэн.<br>Дээрх түр хороо ЧХОУНБГГ, УБГГ-т 2024 оны 03 сарын 12-ны өдөр ажиллсантай холбоотойгоор дэд дарга болон хэлтсийн дарга нарыг холбогдох мэдээ мэдээллээр хангаж ажилласан.<br>“Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцлийг хянан шалгах үүрэг бүхий түр хороо”-ны сонсгол 2024 оны 04 сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсантай холбоотойгоор шаардлагатай мэдээ мэдээллийг бэлтгэж, удирдах албан тушаалтан болон холбогдох албан тушаалтныг мэдээ мэдээллээр хангаж ажилласан.<br>Боомтын хөгжил үндэсний форум-2024-д 2024 оны 03 сарын 26-ны өдөр оролцсон.<br>Эрсдэлийн удирдлагын хэлтсээс зохион байгуулсан “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх онол, практикын асуудал” сэдэвт сургалтад хамрагдаж, бүлгээр ажиллаж, хэлэлцүүлэгт оролцсон.<br>ЧХОУНБГГ-т зохион байгуулагдсан сургалт хэлэлцүүлэгт оролцож, гаалийн улсын байцаагчдыг асуусан асуултад хариулж, санал бодлоо солилцсон.<br>Албан хэрэг хөтлөлтийн edoc.ecustoms.mn цахим системээр 22 бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. | | |

**Нэг. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Англи хэлний ахисан түвшингийн сургалтад хамрагдах | Англи хэлний сургалтад хамрагдсан тоо | Англи хэлний мэдлэгээ сайжруулсан байх | Англи хэлний ахисан түвшийнгийн сургалтад хамрагдаж, сертификат авсан байх | 3 дугаар улиралд англи хэлний ахисан түвшингийн онлайн сургалтад хамрагдаж, англи хэлний сонсох чадварыг 1 түвшнээр ахиулсан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| 2 | Хувь хүний хөгжил, мэдлэг ур чадвараа дээшлүүлж, багшлах эрхийн сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан тоо | МУБИС-аас зохион байгуулдаг “Багшлах мэргэжил” сургалтад хамрагдах | “Багшлах мэргэжил” сертификат авсан байх | Багшлах мэргэжил сертификаттай сургалтанд 2024 оны 04 сарын 10-аас 05 сарын 25-ны өдөр хүртэл суралцаж төгсгөсөн. | 2024.01.01<br>2024.06.30 | 100 |
| 3. | Төрийн албаны тухай, Авлигын эсрэг хууль болон тэдгээрийг дагалдан гарсан журмуудыг мөрдөж ажиллах | Төрийн албаны тухай, Авлигын эсрэг хууль болон тэдгээрийг даган гарсан журмуудыг уншиж судалсан байна. | Төрийн албаны тухай, Авлигын эсрэг хууль болон тэдгээрийг даган гарсан шинэ журмуудыг уншиж судлан мэдлэг олж авсан байна. | Журмуудыг судалж, мэдлэг олж авсан байна. | Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд багтаан үнэн зөв мэдүүлж, АТГ-аас өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

Тайлан гаргасан:

Эм биобэлдмэлийн хяналт хариуцсан
Гаалийн улсын байцаагч ........................................ /М.Пүрэвсүрэн/ 2024 оны 12 дугаар сарын 10 өдөр

1597

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.ПҮРЭВСҮРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хорио цээрийн хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 58 | 9 | 67 | |
| 2 | Хууль тогтоомжийн эрх зүйн актын хэрэгжилт | 59 | 9 | 68 | |
| 3 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | 57 | 8 | 65 | |
| 4 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 57 | 9 | 66 | |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Гаалийн хорио цээрийн гаалийн улсын байцаагчдын чадавхыг дээшлүүлэх | 58 | 8 | 66 | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт | 58 | 8 | 65 | |
| 3 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | 57 | 8 | 65 | |
| 4 | Бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор лабораторийн шинжилгээнд хамруулсан үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх | 57 | 8 | 65 | |
| 5 | Бараа, тээврийн хэрэгслийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтын мэдээ, мэдээллийг гаргаж холбогдох байгууллага, удирдлагыг мэдээллээр хангах, ажлын хэсэгт ажиллах | 59 | 8 | 67 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Гаалийн хорио цээрийн ц8ахимжилт | 58 | 8 | 66 | |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 7 | Хэлтэст ирсэн албан бичгийн бүртгэл хөтлөх, удирдлагын цохолтын дагуу байцаагчдад хүргэх, мэдээллээр хангах | 57 | 9 | 66 | |
| 8 | Гаалийн улсын байцаагчдын сул орон тоо зарласантай холбоотойгоор шалгалтад тэнцсэн гаалийн улсын байцаагчдад хичээл заах | 58 | 8 | 66 | |
| 9 | Даргын өгсөн үүрэг даалгавар болон албан бичгээр ирсэн агуулгын дагуу сургалт, семинар хэлэлцүүлэгт оролцох, үүрэг даалгаварыг биелүүлэх | 57 | 9 | 66 | |
| 10 | Ажлын цаг ашиглалт | 59 | 8 | 67 | |
| **Дундаж оноо:** | | | | 66 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Англи хэлний ахисан түвшингийн сургалтад хамрагдах | 90 | 13 | |
| 2 | Хувь хүний хөгжил, мэдлэг ур чадвараа дээшлүүлж, багшлах эрхийн сургалтад хамрагдах | 100 | 15 | |
| 3 | Төрийн албаны тухай, Авлигын эсрэг хууль болон тэдгээрийг дагалдан гарсан журмуудыг уншиж судлан, мөрдөж ажиллах | 100 | 15 | |
| **Дундаж оноо:** | | | 14.3 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо:** | | **6.6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 |
| 2 | Багаар ажиллах | 7 |
| 3 | Харилцаа | 7 |
| | **Дундаж оноо:** | **7** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *66* |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14.3 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.6 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **93.9** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хорио цээрийн хэлтсийн дарга ............................ (Г.Батмөнх)

........................*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ..............................................(М.Пүрэвсүрэн)

...........................*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***

орлон гүйцэтгэгч ................................ (Г.Энхтайван)

XII/20, 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн
гаалийн улсын ахлах байцаагч ..............................(Ө.Тэгшээ)

2024.12.20 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга ................................ (Р.Отгонжаргал)

...................................(огноо)